



73

СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/04

Хуурч

Хязгаарлалтын дэглэмийг цуцлах тухай

Монгол Улсын засаг, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.11, 59.1.2, 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам"-ын 2.1, 2.8 дахь заалт, "Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2019 оны А/187 дугаар тушаал, Улсын Онцгой комиссын 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 02 тоот тогтоол, Мал эмнэлгийн тасгийн, мал эмнэлгийн Улсын байцаагчийн 2022 оны 05 дүгээр сарын 03-ны өдрийн 20 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрт бүртгэгдсэн мал, амьтны гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх зорилгоор 2022 оны 04 дүгээр 19-ний А/56 тоот захирамжаар төгтөөсөн "Хязгаарлалтын дэглэм"-ийг 2022 оны 05 дүгээр сарын 03-ны өдөр цуцалж, мөн өдрөөс эхлэн хэвийн горимд шилжүүлсүгэй.

2. Уг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу шуурхай зохион байгуулж, өвчний талаарх сэрэмжлүүлгийг иргэдэд тогтмол хүргэж, халдварыг дахин тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулахыг МЭҮН-ийн малын эмч нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга Улсын байцаагч (М.Алтаннавч)-д үүрэг болгосугай.

4. Уг захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарын орлогч (Б.Ууганбаяр)-т даалгасугай.

Уг захирамжийг  
Хүндэтгэн  
Хураар  
Хураар  
Хураар  
Хураар  
Хураар  
Хураар  
Хураар  
Хураар



Ц.БАЯНБААТАР